

Сангийн сайдын 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 6/4577 тоот албан бичгээр санал авахаар хүргүүлсэн тушаалын төсөл

ТӨСӨЛ

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

..... оны сарын өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” (цаашид “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” гэх)-д доор дурдсан агуулгатай 3.8, 4.8-4.11, 7.4 дэх хэсгийг тус тус нэмсүгэй.

“3.8. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гомдол гаргагчийг цахим системээр зохион байгуулах тендерт шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээд эсэх талаар энэ журмын 3.2-т заасан мэдээллийг цахим системээр шалгана.

4.8. Гомдол гаргагч тендерийн баталгааг цуцлаагүй, цуцлах хүсэлт гаргаагүй эсхүл гомдол хянан шийдвэрлэх хугацаанд дуусгавар болгохгүй байх шаардлагатай бөгөөд Сангийн яам тендерийн баталгааны хүчинтэй хугацааг цахим системээр шалгана.

4.9. Тендерт оролцогч энэ журмын дагуу Сангийн яаманд гаргасан гомдлын хуулбарыг ажлын 1 хоногийн дотор цахим системд бүртгэж, илгээнэ.

4.10. Сангийн яамны худалдан авах ажиллагааны бодлогын асуудал хариуцсан нэгжийн холбогдох албан тушаалтан энэ журмын 4.8, 4.9-т шаардлагыг урьдчилсан байдлаар шалгаж, энэ журмын 4.5-д заасан үндэслэл байвал энэ тухай үндэслэлийг зааж, гомдлыг цахим системээр буцааж болно.

4.11. Энэ журмын 4.10-т зааснаар гомдлыг буцаасан нь тендерт оролцогч хуульд заасан хугацааны дотор дахин гомдол гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

7.4. Мэдэгдлийн дагуу баталгаа гаргагч тендерийн баталгааг улсын орлого болгох үүргээ зөрчсөн бол захиалагч төлбөрийг шүүхийн журмаар барагдуулах арга хэмжээ авах ба баталгаа гаргагч цахим системээр баталгаа гаргахад хүлээсэн үүргээ зөрчсөн талаар Төрийн худалдан авах ажиллагааны газарт мэдэгдэнэ.”

Сангийн сайдын 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 6/4577 тоот албан бичгээр санал авахаар хүргүүлсэн тушаалын төсөл

2. Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журмын 2.2, 3.2 дахь хэсгийн “зөвлөх үйлчилгээний хувьд” гэсний дараа “зөвлөхийн жагсаалтад орох санал хүргүүлсэн эсхүл” гэж, 2.3 дахь хэсгийн “/www.tender.gov.mn/” гэсний дараа “(цаашид “цахим систем” гэх)” гэж, 3.4, 4.6 дахь хэсгийн “албан бичгээр” гэсний дараа “эсхүл цахим системээр дамжуулан” гэж, 4.1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэр болгож “Оролцогч захиалагчийн шийдвэрийн эх хувийг хэзээ хүлээн авснаас үл хамааран шийдвэрийг цахим системд байршуулсан өдрөөс гомдол гаргах хугацааг тоолно.” гэж тус тус нэмсүгэй.

3. Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журмын 3.3.1 дэх заалтын “тендерт оролцогч” гэснийг “цахим системээр зохион байгуулснаас бусад тендер шалгаруулалтын хувьд сонирхогч” гэж, 4.2.4 дэх заалтын “тендерийн баталгаа шаардсан” гэснийг “цахим системээр зохион байгуулаагүй” гэж, 4.5 дахь хэсгийн “4.2-т заасан бүрдүүлбэрийн” гэснийг “4.2, 4.8-д заасан” гэж, 4.6 дахь хэсгийн “утсаар болон” гэснийг “утсаар,” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журмын 3.7, 6.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“3.7. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гомдол хянан шийдвэрлэлтийн мэдээллийг улирал бүр цахим системээр олон нийтэд нийтэд нээлттэй байршуулна.

6.3. Сангийн яам гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны тухай мэдээллийг улирал бүр цахим системээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.”

5. Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журмын 4.2.1 дэх заалтын “улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,” гэснийг, 4.5 дахь хэсгийн “утсаар болон” гэснийг тус тус хассугай.

6. Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журмын 4.2.5 дахь заалт, 4.5.1 дэх заалтыг тус тус хүчингүй болсон тооцсугай.

7. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Наранцогт/, Хууль, эрх зүйн газрын дарга /З.Энхболд/-д тус тус даалгасугай.

САЙД

Б.ЖАВХЛАН